

**“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 11 өдөр

№01/01

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон  
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай*

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.3 болон 69.4 дэх хэсгүүдийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 1,502,337 ширхэг хувьцаа эзэмшдэг 6 хувьцаа эзэмшигч оролцсон ба нийт саналын эрх бүхий энгийн хувьцааны 95.38 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдүүлсүгэй.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 95.38 хувийг эзэмшигчид оролцсон тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА: ..... О.МАРАЛ-ЭРДЭНЭ  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮН: ..... Б.СОЛОНГО  
..... Э.БАДАМГАРАВ



“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2024.04.11

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-  
ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн тооллогын комиссын 01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% хувийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ

“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2024.04.11

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах  
зөвлөлийн гишүүдийг сонгох,  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь хэсэг, 62.1.13 болон 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн тооллогын комиссын 01/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ц.Төмөр
2. Т.Билэгт
3. Ч.Цэцэгмаа
4. Б.Батбилэг
5. Б.Батхишиг
6. Б.Баттөр

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Э.Билгүүн
2. С.Бат-Эрдэнэ
3. Б.Жаргал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компаний эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.



Б.БАТБИЛЭГ



**“ГУТАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024.04.11

№03

Улаанбаатар хот

*ТУЗ-ийн төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл болон 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн тооллогын комиссын 01/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн

**ТОГТООХ нь:**

1. “Гутал” ХК-ийн 2024 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг 1 дүгээр хавсралтын дагуу 100 хувийн саналтай баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАТБИЛЭГ